



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УУЛ УУРХАЙН ХҮРЭЭЛЭНГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/68/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: Б.Сэржмядаг  
Утас: 261885 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn  
Аудитор: Д.Зэндмэнэ  
Утас: 261628 Цахим хаяг: zendmened@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Уваа уул” аудит ХХК  
Захирал: Ч.Мөнхтуяа  
Утас: 99108763 Цахим хаяг: uwaaauul.audit@gmail.com

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

1.Аудитын гэрчилгээ .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3.Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	16
3.8 Аудитын гол асуудал .....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт .....	18
4.3 Албан шаардлага .....	18
4.4 Зөвлөмж .....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	20

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
ЗГ	Засгийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



УУЛ УУРХАЙН ХҮРЭЭЛЭНГИЙН  
ЗАХИРАЛ Б.ОРХОНТУУЛ ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2022.02.24 № 07/298  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уул уурхайн хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Уул уурхайн хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>61,298,999.00</b>	<b>70,128,999.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>14,000,000.00</b>	<b>14,000,000.00</b>
33500	Бусад авлага	14,000,000.00	14,000,000.00
33510	Байгууллагаас авах авлага	14,000,000.00	14,000,000.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>47,298,999.00</b>	<b>47,298,999.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	47,298,999.00	47,298,999.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>0</b>	<b>8,830,000.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>0</b>	<b>8,830,000.00</b>
35410	Бичиг хэргийн материал	0	1,680,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0	2,000,000.00
35470	Бусад хангамжийн материал	0	5,150,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>448,174,108.71</b>	<b>408,790,289.91</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>448,174,108.71</b>	<b>408,790,289.91</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>440,647,957.35</b>	<b>403,772,855.79</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	46,277,726.00	46,277,726.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,644,441.44)	(3,966,662.16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	17,250,000.00	0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(17,250,000.00)	0
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	714,947,615.00	714,947,615.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(327,794,567.81)	(361,724,048.69)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,493,280.00	46,493,280.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(42,101,877.25)	(43,725,277.21)
39217	Ном	5,470,222.85	5,470,222.85
39300	Биет бус хөрөнгө	7,526,151.36	5,017,434.12
39301	Програм хангамж	45,167,892.00	45,167,892.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(37,41,740.64)	(40,150,457.88)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>509,473,107.71</b>	<b>478,919,288.91</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>509,473,107.71</b>	<b>478,919,288.91</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>509,473,107.71</b>	<b>478,919,288.91</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	151,495,662.82	151,495,662.82
51200	Хуримтлагдсан үр дүн	336,573,320.74	306,019,501.94
51210	Өмнөх үеийн үр дүн	385,090,079.70	336,573,320.74
51220	Тайлант үеийн үр дүн	(48,516,758.96)	(30,553,818.80)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	21,404,124.15	21,404,124.15
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>509,473,107.71</b>	<b>478,919,288.91</b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>590,486,192.34</b>	<b>500,141,195.50</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>590,486,192.34</b>	<b>500,141,195.50</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>347,167,100.00</b>	<b>348,858,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	347,167,100.00	348,858,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>243,319,092.34</b>	<b>151,283,095.50</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	12,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	243,319,092.34	139,283,095.50
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>639,002,951.30</b>	<b>530,695,014.30</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>639,002,951.30</b>	<b>530,695,014.30</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>633,776,807.96</b>	<b>528,274,707.90</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>278,170,979.00</b>	<b>372,161,099.10</b>
210101	Үндсэн цалин	216,974,058.00	209,877,022.00
210102	Нэмэгдэл	51,654,521.00	33,481,889.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,542,400.00	24,331,998.60
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	104,470,189.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>36,234,787.00</b>	<b>49,986,493.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	25,595,194.47	39,228,393.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,167,773.00	2,689,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,019,019.00	2,151,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	495,491.70	537,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,957,308.83	5,379,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,850,000.00</b>	<b>38,850,000.00</b>
210304	Байрны түрээс	38,850,000.00	38,850,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,126,600.00</b>	<b>12,372,200.00</b>
210401	Бичиг хэрэг	9,167,400.00	4,421,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,625,000.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,334,200.00	3,200,800.00
210404	Ном, хэвлэл	0.00	3,750,000.00
2105	Нормативт зардал	500,000.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	453,500.00
210702	Дотоод албан томилолт	0.00	453,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>227,677,683.00</b>	<b>13,960,997.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	227,677,683.00	11,960,997.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	2,000,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>40,216,758.96</b>	<b>39,990,418.80</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	606,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,516,758.96	39,383,818.80
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,226,143.34</b>	<b>2,420,306.40</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>410,000.00</b>	<b>328,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	328,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>4,816,143.34</b>	<b>2,092,306.40</b>

Уул уурхайн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,325,804.00	1,261,789.90
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,490,339.34	830,516.50
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(48,516,758.96)</b>	<b>(30,553,818.80)</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(48,516,758.96)</b>	<b>(30,553,818.80)</b>



### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>151,495,662.82</b>	<b>21,404,124.15</b>	<b>385,090,079.70</b>	<b>557,989,866.67</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	151,495,662.82	21,404,124.15	385,090,079.70	557,989,866.67
Тайлант үеийн үр дүн	-	-	(48,516,758.96)	(48,516,758.96)
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>151,495,662.82</b>	<b>21,404,124.15</b>	<b>336,573,320.74</b>	<b>509,473,107.71</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	151,495,662.82	21,404,124.15	336,573,320.74	509,473,107.71
Тайлант үеийн үр дүн	-	-	(30,553,818.80)	(30,553,818.80)
<b>2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>151,495,662.82</b>	<b>21,404,124.15</b>	<b>306,019,501.94</b>	<b>478,919,288.91</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>599,486,192.34</b>	<b>500,141,195.50</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>599,486,192.34</b>	<b>500,141,195.50</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>347,167,100.00</b>	<b>348,858,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	347,167,100.00	348,858,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>252,319,092.34</b>	<b>151,283,095.50</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	12,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	252,319,092.34	139,283,095.50
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>599,486,192.34</b>	<b>500,141,195.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>599,486,192.34</b>	<b>500,141,195.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>594,260,049.00</b>	<b>497,720,889.10</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>278,170,979.00</b>	<b>372,161,099.10</b>
210101	Үндсэн цалин	216,974,058.00	209,877,022.00
210102	Нэмэгдэл	51,654,521.00	33,481,889.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,542,400.00	24,331,998.60
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	104,470,189.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>36,234,787.00</b>	<b>49,986,493.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	25,595,194.47	39,228,393.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,167,773.00	2,689,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,019,019.00	2,151,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	495,491.70	537,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,957,308.83	5,379,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,850,000.00</b>	<b>38,850,000.00</b>
210304	Байрны түрээс	38,850,000.00	38,850,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,126,600.00</b>	<b>12,372,200.00</b>
210401	Бичиг хэрэг	9,167,400.00	4,421,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,625,000.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,334,200.00	3,200,800.00
210404	Ном, хэвлэл	0.00	3,750,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	453,500.00
210702	Дотоод албан томилолт	0.00	453,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>227,677,683.00</b>	<b>22,790,997.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	227,677,683.00	20,790,997.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	2,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	606,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	606,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,226,143.34</b>	<b>2,420,306.40</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>410,000.00</b>	<b>328,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	328,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>4,816,143.34</b>	<b>2,092,306.40</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,325,804.00	1,261,789.90

Уул уурхайн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,490,339.34	830,516.50
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>101</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>20</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>348,858,100.00</b>	<b>347,596,310.10</b>	<b>1,261,789.90</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>348,858,100.00</b>	<b>347,596,310.10</b>	<b>1,261,789.90</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>348,530,100.00</b>	<b>347,268,310.10</b>	<b>1,261,789.90</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>268,952,700.00</b>	<b>267,690,910.10</b>	<b>1,261,789.90</b>
Үндсэн цалин	212,729,500.00	209,877,022.00	2,852,478.00
Нэмэгдэл	48,905,600.00	33,481,889.50	15,423,710.50
Унаа хоолны хөнгөлөлт	7,317,600.00	24,331,998.60	(17,014,398.60)
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>36,308,600.00</b>	<b>36,308,600.00</b>	<b>0.00</b>
Тэтгэврийн даатгал	25,550,500.00	25,550,500.00	0.00
Тэтгэмжийн даатгал	2,689,500.00	2,689,500.00	0.00
ҮОМШӨ-ний даатгал	2,151,600.00	2,151,600.00	0.00
Ажилгүйдлийн даатгал	537,900.00	537,900.00	0.00
Эрүүл мэндийн даатгал	5,379,100.00	5,379,100.00	0.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,850,000.00</b>	<b>38,850,000.00</b>	<b>0.00</b>
Байрны түрээс	38,850,000.00	38,850,000.00	0.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,312,200.00</b>	<b>1,312,200.00</b>	<b>0.00</b>
Бичиг хэрэг	111,400.00	111,400.00	0.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,800.00	1,200,800.00	0.00
<b>Нормативт зардал</b>	<b>500,000.00</b>	<b>500,000.00</b>	<b>0.00</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00	0.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,000,000.00</b>	<b>0.00</b>
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	0.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>606,600.00</b>	<b>606,600.00</b>	<b>0.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	606,600.00	606,600.00	0.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>328,000.00</b>	<b>328,000.00</b>	<b>0.00</b>
Бусад урсгал шилжүүлэг	328,000.00	328,000.00	0.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	328,000.00	328,000.00	0.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>348,858,100.00</b>	<b>347,596,310.10</b>	<b>1,261,789.90</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>348,858,100.00</b>	<b>347,596,310.10</b>	<b>1,261,789.90</b>
Улсын төсвөөс санхүүжих	348,858,100.00	347,596,310.10	1,261,789.90
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0	0.00
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>20</b>	<b>20</b>	<b>0.00</b>
Удирдах ажилтан	1	1	0.00
Гүйцэтгэх ажилтан	18	18	0.00
Үйлчлэх ажилтан	1	1	0.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>151,283,095.50</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>151,283,095.50</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>150,452,579.00</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>104,470,189.00</b>
Гэрээт ажлын хөлс		104,470,189.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>13,677,893.00</b>
Тэтгэврийн даатгал		13,677,893.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>11,060,000.00</b>
Бичиг хэрэг		4,310,000.00
Тээвэр, шатахуун		1,000,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		2,000,000.00
Ном, хэвлэл		3,750,000.00
<b>Томилолт, зочны зардал</b>		<b>453,500.00</b>
Дотоод албан томилолт		453,500.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>20,790,997.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		20,790,997.00
<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>830,516.50</b>
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>151,283,095.50</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>151,283,095.50</b>
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		12,000,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		139,283,095.50

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана гэж заасны дагуу Уул уурхайн хүрээлэнгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлт, авлага, цалин хөлстэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-наас 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд “Уваа уул аудит” ХХК-ийн аудитор Б.Буяндэлгэр, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Ч.Мөнхтуяа хэрэгжүүлсэн.

Түүх, угсаатны зүйн хүрээлэн нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Уваа Уул Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Уул уурхайн хүрээлэнгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Удирдлага зохион байгуулалтын чанарыг дээшлүүлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгаанд суурилсан инновацыг хөгжүүлэх”-д оршино.

Мөн Монгол Улсад уул уурхайн салбарыг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлэх, олон улсын түвшинд хүрсэн эко бүтээгдэхүүн үйлдвэрлэх судалгаа явуулах, эрдэм шинжилгээ ТЭЗҮ, зураг төсөл, лаборатори, хагас үйлдвэрлэлийн туршилт хийх чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг БШУС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” тушаалын хавсралт “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь БШУС-ын 2021 оны “бодлогын баримт бичиг, журам батлах тухай” А/26 дугаар тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.



Дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд тайлант хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Уул уурхайн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 639,003.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,390.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсон нь 2021 онд жилийн эцсийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлт материаллаг дүнтэй буурсан тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Аудитыг гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 530,695.0 мянган төгрөгийн 1 хувиар буюу 5,307.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоов.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Уул уурхайн хүрээлэнгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21,190.5 мянган төгрөгөөр буурч, материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	14,000.0	14,000.0	-
Урьдчилж гарсан зардал	47,299.0	47,299.0	-
Бараа материал		8,830.0	8,830.0
Үндсэн хөрөнгө	448,174.1	408,790.3	(39,383.8)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>509,473.1</b>	<b>478,919.3</b>	<b>(30,553.8)</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	509,473.1	478,919.0	(30,554.1)
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>509,473.1</b>	<b>478,919.0</b>	<b>(30,554.1)</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Үндсэн хөрөнгө данс тайлант хугацааны элэгдэлийн зардлаас шалтгаалан 39,383.8 мянган төгрөгөөр буурсан байна.
- Урьдчилгаа дансны 47,299.0 мянган төгрөгийн үлдэгдэл нь 2017-2019 онд хэрэгжиж дууссан төслийн ажлыг захиалагч хүлээн аваагүйтэй холбоотой байна. Энэ нь тайлант онд гарсан зардлаа хүлээн зөвшөөрч, үйл ажиллагааны үр дүн үнэн зөв илэрхийлэгдэхгүйд хүргэж байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус хүрээлэнгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 483,200.7 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 483,200.7 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал зардлыг 134,342.6 мянган төгрөгөөр бууруулан 348,858.1 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 348,858.1 мянган төгрөгийн улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 348,858.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 347,596.3 мянган төгрөгийг зарцуулж, 1,261.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөг/						
Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71805	Шинжлэх ухаан, технологи	348,858.1	347,596.3	1,261.8	99.6
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	348,530.1	347,268.3	1,261.8	99.6
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	328.0	328.0	-	100.0

Цалингийн зардлыг 1,261.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулж төсвийн нийт зардлын гүйцэтгэл 347,596.3 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд суурь судалгааны төслийн санхүүжилтээр 12,000.0 мянган, эрдэм шилжилгээний ажилтнуудын ТЭЗҮ боловсруулах, шинжилгээний орлогоор 139,283.0 мянган, нийт 151,283.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлсний зардалд 104,470.1 мянган, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 13,677.8 мянган, бараа материалын зардалд 11,060.0 мянган, бараа үйлчилгээний бусад зардалд 20,791.0 мянган төгрөгийг зарцуулж, 830.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Уул уурхайн хүрээлэнгийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт тусгайлан гаргадаггүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө байхгүйгээс үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан 104,470.2 мянган цалин хөлс авсан, төсвийн бүлэг дотор зардлын хэтрэлт үүсгэж байгаа зэргийг цаашид анхаарах шаардлагатай байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Уул уурхайн хүрээлэнгийн 2021 онд нийт 587,593.2 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 149 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Завсрын аудитаар нийт 86,525.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 6 зөвлөмж өгч, жилийн эцсийн аудитаар дахин хянахад 85,525.9 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,360.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн актын биелэлт 100 хувь, 54,642.6 мянган төгрөгийн 2 албан шаардлагын биелэлт 100 хувь, 18,556.7 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн биелэлт 66.6 хувьтай байна.

*Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,360.8	1	1,360.8	-	-	100
Албан шаардлага	2	54,642.6	2	54,642.6	-	-	100
Зөвлөмж	3	18,556.7	2	4,556.7	1	14,000.0	66.6
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>74,560.1</b>	<b>5</b>	<b>60,560.1</b>	<b>1</b>	<b>14,000.0</b>	<b>88.8</b>

“Амгуулин” ХХК-аас авах 2016 онд үүссэн 14,000.0 мянган төгрөгийн он удаан жил болсон эрсдэлтэй авлагыг барагдуулах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант хугацааны эцэст үүссэн авлага дансны үлдэгдэл, байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,193.6 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 1 албан шаардлага хүргүүлж, 2,193.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 2,193.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг байдлаас 3,113.4 мянган төгрөгөөр бага тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

##### 4.3 Албан шаардлага

"Урьдчилгаа" дансанд бүртгэсэн 47,299,000.00 төгрөгийн үлдэгдэл нь 2017-2019 онуудад хэрэгжүүлж дууссан "Ашигт малтмалын ордыг ашиглах дэвшилтэт, шинэ технологи боловсруулан нэвтрүүлэх судалгаа" төсөл, Амгуулин ХХК-ийн "Өргөний орд"-ны ТЭЗҮ хийлгэсэн 14,000,000.00 төгрөгийн он удаан жил болсон авлагыг барагдуулах ажил зохион байгуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөх.

##### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

###### 1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 194,143.2 мянган төгрөгийн хөрөнгө байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" 7.1-д "төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, ТӨБЗГ-аас ашиглах жил, үнэ шинэчлэн тогтоох зөвшөөрөл авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

###### Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн тооллогын баримтад эд хариуцагчийг карт, тооцоо бодсон баримт, тооллогын комиссын илтгэх хуудас, өмч хамгаалах зөвлөлийн тэмдэглэл, байгууллагын удирдлагад танилцуулсан тэмдэглэл, тооллогын баталгаа хийгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 1-д. “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй...”, 72 дугаар зүйлийн 4-д “Тооллогын комисс дараах үүрэгтэй...” гэж заасантай нийцэхгүй үнэлгээ ба хуваарилалт, тохиолдсон байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тооллогыг ажлыг чанартай явуулж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

**2. Зардлын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Нягтлан бодогч өөртөө сар бүр 25 хувийн ур чадварын нэмэгдлийг тооцож нийт 2,193.6 мянган төгрөгийг олгосон нь Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалын хавсралт “төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 5-д Ажилтанд олгож байгаа ур чадварын нэмэгдлийг заасан хязгаарт багтаан нэмэгдүүлэх, бууруулах асуудлыг улирал бүр хэлэлцэн шийдвэрлэж байна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Улирал бүр ажлын үзүүлэлтийг үнэлж дүгнэдэг, зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
							тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	ШУТС-УУХ	АХГ-2022/68/НА-СТА-ТШЗ	Өмнөх оны аудитын зөвлөмж хэрэгжүүлээгүй авлага, Урьдчилгаа дансны үлдэгдэл хаагдаагүй	Өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөх.	1	-					1	-				
2	ШУТС-УУХ	АХГ-2022/68/НА-СТА-ТШЗ	Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 194,143.2 мянган төгрөгийн хөрөнгө байна	ТӨБЗГ-н тогтоолын хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоох, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	-							1	-		
3	ШУТС-УУХ	АХГ-2022/68/НА-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгийн тооллогын баримтад эд хариуцагчийг карт, тооцоо бодсон баримт, тооллогын комиссын илтгэх хуудас, өмч хамгаалах зөвлөлийн тэмдэглэл, байгууллагын удирдлагад танилцуулсан тэмдэглэл, тооллогын баталгаа хийгдээгүй	Тооллогыг ажлыг чанартай явуулж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.	1	-							1	-		
4	ШУТС-УУХ	АХГ-2022/68/НА-СТА-ТШЗ	Нягтлан бодогч сар бүр 25 хувийн ур чадварын нэмэгдэл нийт 2,193.6 мянган төгрөг авсан	Улирал бүр ажлын үзүүлэлтийг үнэлж дүгнэх, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	2,193.6							1	2,193.6		
Санхүүгийн тайлангийн аудитын дүн					4	2,193.6	-	-	-	-	1	-	-	-	3	2,193.6
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
Нийцлийн аудитын дүн							-	-	-	-	-	-	-	-		
Нийт дүн					4	2,193.6	-	-	-	-	1	-	-	-	3	2,193.6



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 34/20150058

Улаанбаатар хот

АХГ-2022/68/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Уул уурхайн хүрээлэнгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Урьдчилгаа" дансанд бүртгэсэн 47,299,000.00 (Дөчин долоон сая хоёр зуун ернөсөн мянган) төгрөгийн үлдэгдэл нь 2017-2019 онуудад хэрэгжүүлж дууссан төсөл хаагдаагүй, Амгуулин ХХК-аас авах 14,000,000.00 (Арван дөрвөн сая) төгрөгийн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Уул уурхайн хүрээлэнгийн захирал Б.Орхонтуул, нягтлан бодогч М.Дөлгөөн нарт даалгав

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ;  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
"УВАА УУЛ АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ;  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ  
Ч.МӨНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, "Бага" тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264730

110.10.10.20\Bichig\_Kherig\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Газар-54 Docx

001080158





